



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 3 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 6-46

Улаанбаатар хот

Дүүргүүдэд Газрын харилцааны алба байгуулах тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын 1995 оны 143 дугаар тогтоолын 4-р заалтыг үндэслэн Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн Засаг даргын дэргэд Газрын харилцааны албыг байгуулж ажиллуулахыг тухайн дүүргийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

Хоёр. Дүүргийн Газрын харилцааны албаны үлгэрчилсэн дүрмийг хавсралтаар баталж, орон тооны хязгаарыг 4 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Газрын харилцааны албаны орон тоо, төсвийг баталж мэргэжлийн боловсон хүчнээр бүрдүүлж ажиллуулахыг холбогдох дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

Дөрөв. Дүүргүүдийн Газрын харилцааны албаныг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн алба / Ж.Даваабаатар/, Хот байгуулалт, инженерийн байгууламжийн хэлтэс /Л.Нямсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Дүүргүүдийн газрын харилцааны албадын үлгэрчилсэн түр дүрэм

2000-02-28

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дүүргийн газрын харилцааны албаны /цаашид энэ дүрэмд алба гэх/ зорилго нь дүүргийнхээ нутаг дэвсгэр дээр хот төлөвлөлтийн болон газар зохион байгуулалтын батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу газрыг зөв зохистой ашиглуулах, эзэмшүүлэх, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, газар төлбөрийг хуримтлуулах, газрын мэдээллийн санг бүрдүүлэх, газрын харилцааны маргааныг зохицуулах, газрын сангийн данс, бүртгэл, газрын харилцааны талаар төрөөс болон нийслэлийн төр захиргааны удирдах байгууллагаас явуулж буй нэгдсэн бодлогыг дүүргийнхээ нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, биелэлтэнд нь хяналт тавихад оршино.

1.2 Энэхүү алба нь Нийслэлийн газрын харилцаа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн алба, хотын захирагчийн ажлын албаны мэргэжлийн удирдлагаар хангагдаж дүүргийн Засаг даргын дэргэд үйл ажиллагаа явуулна.

1.3 Алба нь Нийслэлийн Засаг даргын сонгуулийн хугацааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгэм зорилт, нийслэлд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөртэй уялдсан жил улирлын төлөвлөгөөтэй ажиллаж, ажлаа хагас бүтэн жилээр НГХҮХХБА-нд тайлагнаж байна.

1.4 Дүүргийн газрын харилцааны албаны дарга нь газар зохион байгуулалтын мэргэжлийн хүн байх бөгөөд дарга болон мэргэжилтнүүдийг нийслэлийн Газрын ерөнхий даамалтай зөвшилцөн үндсэн дээр дүүргийн Засаг дарга томилно.

1.5 Алба нь хэвлэмэл хуудас, тамга тэмдэг, данстай байна.

1.6 Албаны дарга, мэргэжилтнүүд нь улсын байцаагчийн эрхтэй байна.

Хоёр. Дүүргийн газрын харилцааны албаны үүрэг

2.1 Эрх бүхий удирдах дээд байгууллагын шийдвэрээр дүүргийн нутаг дэвсгэрийг хороодод хуваарилан хилийн заагийг баталгаажуулах

2.2 Нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийн төсөл боловсруулахад саналаа өгөх, нийслэлээс батлагдсан хөтөлбөрийн дагуу дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

2.3 Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд газар ашиглуулах, эзэмшүүлэх эрх олгохдоо хот байгуулалт, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх ашиглуулах хамгаалах хөтөлбөрт нийцүүлэн гаргасан хотын Мэргэжлийн комиссын шийдвэрийг үндэслэн гаргасан байршилт тогтоох тухай Нийслэлийн Засаг даргын Захирамжийн дагуу дүүргийнхээ нутаг дэвсгэр дээр газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан гэрээ байгуулж, гэрчилгээ олгох

2.4 Газар эзэмшигч, ашиглагчдын эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэх, эзэмшил, ашиглалтанд олгогдсон газрын байршил, хэмжээг жижүүрийн зурагт оруулах зэрэг ажлын журамд заасан хугацааны дотор зохион байгуулах

2.5 Монгол Улсын Газрын төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын тогтоол Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар баталсан газрын төлбөрийн хувь, хэмжээг баримтлан газрын төлбөрийг хуримтлуулах ажлыг зохион байгуулах

2.6 Газар эзэмшигч, ашиглагчдад олгогдсон газрын хэмжээ, зориулалт, тогтоосон цорм нормативыг мөрдөж хяналт тавин ажиллах

2.7 Дүүргийн газрын нэгдмэл сангийн данс бүртгэл, газрын хуваарилалт, ашиглалт, хамгаалалт, тэдгээрийн ходолгөөний тайланг хуульд заасан хугацааны дотор гаргаж НГХҮХХБ Албанд шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлэх. дүүргийнхээ газрын харилцаатай холбогдсон мэдээллийг Газрын кадастрын бүртгэлийн хуульд заасан үзүүлэлтээр мэргэжлийн байгууллагаас өгөгдсөн стандарт загварын дагуу хугацаанд нь гаргаж өгөх

2.8 Газар ашиглуулах эзэмшүүлэх, газрын харилцааг зохицуулах, хот байгуулалт, барилгажилтын талаар нийслэлийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Гурав. Дүүргийн газрын харилцааны албаны эрх

3.1 Дүүргийн нутаг дэвсгэрт газрын тухай хууль тогтоомж, Нийслэлд, дүүргийн Засаг даргыг шийдвэрийг зорчсон этгээдэд түүний гэм буруу зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан Монгол Улсын Газрын тухай хуулийн 59-р зүйл, болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу арга хэмжээ авах

3.2 Газарт хохирол учруулсан, гэм буруутай этгээдээ эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг нөхөн толүүлж хохирлыг арилгахтай холбогдсон зардлыг гаргуулах

3.3 Газрын холбогдох, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл шийдвэргүйгээр хууль бусаар ашигласан, эзэмшээд, барилга байгууламж дур мэдэл барьсан болон барилдсан, газрыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгосон, зориулалтын бусаар эзэмшиж ашигласан бол уг газрыг ашиглах, эзэмших эрхийг хүчингүй болгох, газрын хураан авч буруутай этгээдийг торгон хууль бусаар газар эзэмшиж ашиглан үйлчилгээ явуулж олсон орлогыг улсын орлогод хураах

3.4 Дүүргийн нутаг дэвсгэрт газрын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгүүд болон газрыг үр ашигтай зохистой ашиглах, хамгаалах, талаархи шийтгэл шаардлагын биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг нь үнэн гэнэ талаар дүүрэг болон хороодын Засаг даргын сонсголыг Дүүргийн ИТХ болон хорооны иргэдийн нийтийн хурал, дээд шатны Засаг даргад авч хэлэлцэхийг санал болгох

3.5 Дүүргийн нутаг дэвсгэр дээрхи өмчийн бүх хэлбэрт хамаарах үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийн ашиглалт, эзэмшлийн газар, тэдгээрийн барьж байгуулж буй барилга байгууламжинд саадгүй нэвтрэн орж Газрын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих, холбогдох бичиг баримтыг шаардах, зөрчил арилгах талаар шаардлага тавих

3.7 Дүүргийнхээ нутаг дэвсгэрт газрын харилцааг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, тогтоогдсон дүрэм журам буюу хот байгуулалтын болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцээгүй гарсан Мэргэжлийн комиссын шийдвэрийн талаар дээд шатны албан тушаалтад гомдол гаргах

3.8 Дүүргийнхээ газар ашиглалт, хамгаалтыг сайжруулах, газрын төлөв байдал чанарт захиалгат болон ээлжит бус хянан багалигаа хийлгэх, доройтсон газрын нөхөн сэргээх, зэрэг газар зохион байгуулалтын бүх төрлийн арга хэмжээ болон газрын харилцааг боловсронгуй болгохтой холбогдсон төсөл, хөтөлбөр, санал боловсруулан дээд шатны мэргэжлийн байгууллагаар уламжлуулан холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх

3.7 Нийслэлийн тусгай хэрэгцээ, ногоон бүсийн газарт нийслэлийн хөгжилд чухал ач холбогдол бүхий ажил үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг тухайн дүүргийн Засаг даргаар уламжлуулан Мэргэжлийн комисс болон Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх